**ДУНДГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН**
**2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

**2023.12.05**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /сая/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| **“СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаа цахимжуулж, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулж инновацийг дэмжигч итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй, төрийн үйлчилгээний байгууллага байна.** | | | | | | | | |
| **НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | | |
| **1** | **<u>Зорилт 1</u>** Улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулж, техник, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлнэ | Улсын төсөв, орон нутгийн төсөв, бусад эх үүсвэр | Шинээр хангалт хийсэн төхөөрөмжийн тоо | 2 | 1 | 1 | Улсын бүртгэгч нарт зөөврийн компьютер 6ш, зөөврийн 4жи төхөөрөмж 2 ширхэг тус бүрийг шийдвэрлүүлж цахим бүртгэлд ашиглаж байна. Мэдээллийн технологийн ажилтны дэлгэцийг шинэчилж хэмжээг томруулсан. Үйлчилгээний танхимд дуу, дүрсний ялгаралтай 360 эргэлттэй камерийг суурилууллаа. | 100/100 |
| 1.1 | Бүртгэлийн үйлчилгээг мэдээллийн технологийн шинэ дэвшилтэт арга хэрэгслээр үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх | 20,0 сая | Бүртгэлийн үйлчилгээний киоск машины тоо | 0 | 1 | - | Бүртгэлийн үйлчилгээний киоск машинаар дамжуулан иргэний бүртгэлийн 12 төрлийн лавлагаа, иргэний үнэмлэх дахин авах, гадаад паспортын зураг илгээх, оршин суугаа хаягийн шилжилт хөдөлгөөн , цахим иргэний үнэмлэхийн мэдээлэл, тоон гарын үсэг авах зэрэг 5 төрлийн үйлчилгээ мөн 28 төрлийн бүртгэлийн үйлчилгээний төлбөр тооцоог төлөх боломжтой болсон. 20.0 сая төгрөгийн санжүүжилтээр УБЕГазраар шийдвэрлүүлэн аймгийн ЗДТГ-ын цахим үйлчилгээний хэсэгт байршуулсан. | 100 |
| 1.2 | Улсын бүртгэлийн хэмжээнд дагаж | Бусад эх | Хууль, дүрэм, | 4 | 3 | 4 | Тайлант хугацаанд 21 удаагийн сургалт | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мөрдөж байгаа хууль, дүрэм, журмыг сурталчлах, мэдээллийн өдөрлөг сумдад зохион байгуулах | үүсвэр, байгууллагын төсөв 3,5 сая | журмыг сурталчилсан тоо | | | | мэдээллээр 7800 иргэнд бүртгэлийн үйл ажиллагааг сурталчилж ажилласан байна.<br>УБЕГазар, бүртгэлийн хууль тогтоомж, үйл ажиллагаатай холбоотой 46 мэдээ мэдээллийг УБЕГазрын вэйб хуудас, Улсын бүртгэлийн ерөнхий газрын фэйж хуудаснаас Дундговь улсын бүртгэлийн хэлтэс нээлттэй групп, Бүртгэлийн хэлтсийн фэйж хуудсанд шэйр хийж түгээсэн.<br>-Сайнцагаан сумын ахмадуудад иргэний үнэмлэх дахин захиалах, тоон гарын үсэг хэрхэн авах түүний хэрэглээ сэвдээр мэдээлэл хүргэж зөөврийн төхөөрөмжөөр тоон гарын үсэг олголоо. Нийт 52 ахмад хамрагдсан."Хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах" ажлын хүрээнд "Бүртгэгч-багш" өдөрлөгийг 2023 онд 14 сумын ЕБСургуулийн сурагчдын дунд зохион байгуулж 580 хүүхдийг хамруулж мэдээлэл хүргэж үйл ажиллагаанд татан оролцуулсан.<br>Аймгийн Засаг даргатай хамтран зохион байгуулсан “Иргэдээ сонсье-2023” арга хэмжээг 15 суманд зохион байгуулж 1890 иргэдэд зөвлөгөө өгч, бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, гарын авлага, боршур тараалаа. Хуулийн байгууллагуудын нэгдсэн өдөрлөг ПРОБОНО—д оролцож 56 иргэнд мэдээлэл, үйлчилгээ үзүүллээ. Алслагдсан баг Буянт, Сайхан-Овоо сумдад өдөрлөг зохион байгуулж 4 жи төхөөрөмж ашиглан ТГҮ олгон иргэдэд бүртгэлийн үйлчилгээг үзүүллээ. ХБИргэдэд гэрээр үйлчилгээ үзүүлэн аймгийн ХБИТөвтэй хамтран өдөрлөгийн арга хэмжээ зохион байгуулж 83 иргэнийг хамруулллаа.. | |
| 1.3 | Тоон гарын үсгийг хэрэглээнд | - | тоон гарын | 30 | 200 | 300 | 2023 оны 11 сарын байдлаар 528 албан | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нэвтрүүлэх, ашиглах | | үсгээр баталгаажиж хүргүүлсэн албан бичгийн тоо | | | | бичигт тоон гарын үсэг зурж цахимаар илгээсэн байна. Тайлант хугацаанд ТГҮсгийн хүчинтэй хугацааг сунгуулж баталгаажуулсан. | |
| **2** | **<u>Зорилт 2</u>.** Цахим бүртгэл, мэдээллийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээг цахим орчинд авах хувийг нэмэгдүүлнэ | - | Цахимаар үйлчилгээ авсан иргэдийн эзлэх хувь | 0,2 | 0,5 | 0,5 | 2023 онд бүртгэлийн үйлчилгээг 14130 иргэн иргэн авсан байх ба үүний 16,8 хувийг цахимаар авсан байна. Сүүлийн хагас жил цахим хөгжлийн яам байгуулагдсанаар эрс сайжирсан. | 100/95 |
| 2.1 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia-аар үйлчилгээ авах аргачлалыг зааж үйлчлүүлэх иргэдийн тоог нэмэгдүүлэх | - | Үйлчлүүлсэн иргэдийн тоо | 25 | 30 | 30 | 2023 онд E-Mongolia цахим системээс гэрлэсний бүртгэлгүй 84 лавлагаа, гэрлэлтийн бүртгэлийн 115, иргэний үнэмлэх дахин захиалсан 61, иргэний үнэмлэхийн лавлагаа 930, төрсний гэрчилгээний лавлагаа 300, оршин суугаа хаягийн лавлагаа 750 нийт 2240 иргэн бүртгэлийн лавлагаа мэдээлэл авч үйлчлүүлсэн байна. Нийт лавлагааны 88,3 хувийг иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, хаягийн лавлагаа эзэлж байна.<br>Хуулийн этгээдийн оноосон нэрийг e-mongolia системээр баталгаажуулалт хийж 529, e-business.mn ээр нийт 741, нэрийг хүлээн авч татгалзсан 491, зөвшөөрсөн 139, баталсан 111 оноосон нэрийн бүртгэлийг баталгаажуулсан.<br>эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн лавлагаа-169, үл хөдлөх хөрөнгийн жагсаалтын лавлагаа-90, үл хөдлөх хөрөнгөтэй эсэх лавлагаа-58 нийт 317 иргэн авсан байна. | 100 |
| 2.2 | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг сумдад үзүүлэх эрхийн тоог нэмэгдүүлэх | - | Бүртгэлийн үйлчилгээ үзүүлж байгаа сумдын тоо | 1 | 0 | 2 | Дэлгэрхангай сумын бүртгэгч сумандаа эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ үзүүлж байгаа ба Хулд, Дэрэн сумын бүртгэгч нар Эрхзүйч мэргэжлээр | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | суралцан төгссөн. Мэргэшүүлэх сургалтад хамрагдаж Говь-Угтаал, Цагаандэлгэр сумын бүртгэгч ЭХЭУБҮйлчилгээ үзүүлж мэдүүлэг авч байна. Цаашид бүх сумдад ЭХЭУБүртгэлийн үйлчилгээг үзүүлэх чиглэлтэйгээр боловсон хүчнээ мэргэшүүлж байна. | |
| 2.3 | Газар, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн дундын мэдээллийн санд өөрчлөлт оруулах | - | Өөрчлөлт оруулсан хувь | 0 | 15 | 15 | Үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн гэрчилгээний шилжилт хөдөлгөөний үед аймгийн ГХБХБГ-тай хамтран ажиллаж шинэ хаягжуулалтаар кадастрын зураг, хаягийн тодорхойлолтыг хүлээн авч бүртгэж хэвшсэн бөгөөд эрх шилжих 1330 бүртгэлийг шинэ хаягжуулалтаар хүлээн авч бүртгэлээ. Тус онд хүлээн авсан 2981 бүртгэлийн **44.6** хувьд нь хаягийн өөрчлөлт оруулсан байна. | 100 |
| 2.4 | Цахим төлбөрийн системийн тоог нэмэгдүүлэх | ОНТөсөв /10.0 сая.төг/ | Төхөөрөмжийн тоо | 1 | 2 | 3 | Эрдэнэдалай, Дэрэн сумдын ИТХурлаар орон нутгийн санхүүжилтээр /тус бүр 5,0 сая төгрөг/ гүйцэтгэх ажлын жагсаалтад оруулан батлуулж төлбөрийн Гэрэгэ системийг бүрэн нэвтрүүллээ.<br>Сайнцагаан суманд төлбөрийн пос машин УБЕГ-ын санхүүжилтээр нэвтрүүлж үйлчилгээний шат дамжлагыг бууруулаа. Пос машин, зөөврийн төхөөрөмжийг ашиглаж баг, хурлын танхим, байгууллагуудаар үйлчилгээ явуулахад ашиглаж байна. Аймгийн ЗДТГ-ын үйлчилгээний угтах хэсэгт бүртгэлийн киоск машиныг ПОС-той холбож төлбөр төлөх боломжийг нэмэгдүүллээ. | 100 |
| 2.5 | Гадаад паспортын бүртгэлийн эрх бүхий нэгжийг нэмэгдүүлэх | - | Бүртгэл хөтлөх эрх бүхий нэгжийн тоо | 2 | 0 | 2 | Эрдэнэдалай сум болон, Киоск машинаар Гадаад паспорт дахин авах цэгийн тоог нэмэгдүүлж ажиллалаа. | 100 |
| 2.6 | Аймаг сумын ИТХ-ын нөхөн | УТөсөв 5,4 | Сонгуулийн | - | 100 | - | "Аймаг, нийслэл, сум, дүүргийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сонгуулийн хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах | сая | календарчилсан төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | | | | иргэдийн Төлөөлөгч дийн Хурлын сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх журам"-ын 4.1.3, 4.1.5-д заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтад сонгуулийн насны иргэдийн мэдээлэл болон "Түр хасав" нэмэлт тэмдэглэгээг үнэн зөв тусгагдсан эсэхийг хянаж календарчилсан төлөвлөгөөг 100 хувь биелүүлэн мөрдөж ажиллав. Дундговь аймгийн хэмжээнд:<br>1. Адаацаг сум 10-2-3 дугаар хэсэг 318 сонгогч "түр хасав" тэмдэглэгээтэй 4 иргэн,<br>2. Хулд сум 10-13-1 дүгээр хэсэг 314 сонгогч "түр хасав" тэмдэглэгээтэй 3 иргэн<br>3. Баянжаргалан сум 10-3-1 дүгээр хэсэг 188 сонгогч "түр хасав" 3 тэмдэглэгээтэй<br>4.Өлзийт сум 10-10-3 дугаар хэсэгт 223 сонгогч "түр хасав" тэмдэглэгээтэй 2 тус тус бүртгэлтэй бөгөөд нэрсийн жагсаалтад тулгат хийхэд зөрчилгүй, хэвлэгдсэн лавлагаагүй байна. Үүрэг даалгаврын хэрэгжилтийг 2023 оны 06 сарын 14-ны өдөр хүргүүллээ. | |
| **ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | | |
| 3 | **Зорилт 3.**<br>Улсын бүртгэлийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж иргэдээс ирүүлэх гомдлын тоог бууруулна | - | Үйлчилгээтэй холбоотой гомдлын тоо | 2 | 0 | 0 | Засгийн газрын 11-11, Аймгийн Олон нийттэй харилцах утас 7059106, Хэлтсийн 70592435, УБЕГазар болон хэлтсийн удирдлагад цахимаар болон бичгээр, амаар үйл чилгээтэй холбоотой гомдол бүртгэгдээгүй. | 100/100 |
| 3.1 | Улсын бүртгэлийн хууль, журмын биелэлтэд хяналт тавих замаар бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг хангах | - | Хяналт шалгалтын төлөвлөгөөний | 90 | 100 | 100 | Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, улсын бүртгэл болон түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжилтийн хувь | | | | аливаа алдаа, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, улсын бүртгэлийн ажилтны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтийг хянах зорилтын хүрээнд хяналтын улсын байцаагчийн хяналт шалгалтын төлөвлөгөөг улирал бүрээр 6 заалтын хүрээнд гаргаж биелэлтийг тооцож ажиллалаа. Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 100%. 2023 онд 2650 бүртгэлд хяналт хийж 171 зөрчлийг илрүүлэн газар дээр нь засварлаж ажиллав. | |
| 3.2 | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулах, тайлагнах, системд байршуулах | - | Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хувь | 100 | 100 | 100 | Жилийн эцсийн санхүүгийн тайланг 5 дугаар сарын 1-ний дотор, Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 5 дугаар сарын 1-ний дотор, Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтыг тайлагнах (Бүтэн жилээр, хагас жилээр), Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр), Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр), гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилт, явц байдлын талаарх мэдээллийг мэдээлэх хуулийн заалтыг мөрдөж дутагдал үүсгэлгүй ажилласан. | 100 |
| | | - | Байршуулбал зохих мэдээллийн хувь | 100 | 100 | 100 | 1-ээс 11-р сард нийт 127 мэдээллийг 100 хувь бүрэн байршуулсан. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3 | Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх, мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд хүргүүлэх | - | Зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийн хувь | 100 | 100 | 100 | Тус хэлтсийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хувийн аудитын компани 2023 оны 2 дугаар сард аудит хийж санхүүгийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй, “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт авсан. | 100 |
| 3.4 | Хэлтсийн архивын тоо баримтад сэдэвчилсэн тооллого хийх | - | Тооллого хийсэн тоо | 0 | - | 1 | Хуулийн этгээдийн хувийн хэрэг, архивын тоо бүртгэлээр нийт 1,426 ширхэг байгаа бөгөөд бүртгэл, нэмэлт өөрчлөлт хийгдэн архивч орж байгаа хувийн хэргийг тухай бүр архивт байршуулж байна.<br>2023 онд хуулийн этгээдийн бүртгэгч нь нийт 169 ширхэг хувийн хэрэгт нэмэлт өөрчлөлт оруулан архивт байршуулсан байна. Шинээр хуулийн этгээд бүртгүүлсэн 54 хувийн хэргийг цахим санд оруулан нэг бүрчлэн бүртгэл хийж архивд ба йршуулсан.<br>Хуулийн этгээдийн хувийн хэрэгт сэдэвчилсэн тооллогыг ажлын хэсэг томилогдон хийж гүйцэтгэлээ. Илэрсэн зөрчилгүй илтгэх хуудсыг бичиж даргын зөвлөлд танилцуулав. | 100 |
| 3.5 | Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах | - | Төлөвлөгөөний биелэлтийн хувь | 90 | 50 | 100 | Эрсдэлийн төлөвлөгөөний биелэлт 100 хувь бөгөөд төсвийн өр үүсэх эрсдэл үүссэн. Тооцоолол, албан бичиг хүсэлтийг санхүүд хүргэж шийдвэрлүүлсэн. Цалингийн санд 30,0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт шийдвэрлүүлэв. Үнэт цаасны тайланг сар бүр бүртгэгч нараас авч нэгтгэсэн тайланг УБЕГ-т хүргүүлж байна. | 100 |
| 3.6 | Аймгийн хэмжээнд мэдээллийн санг үнэлж дүгнэлт гарган мэдээллийн санг цэгцлэх | - | Зөрүүтэй мэдээллийг илрүүлж засвар өөрчлөлт хийсэн тоо | 0 | 50 | 100 | Улсын бүртгэлийн ерөнхий газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын хамтарсан баг хаягийн мэдээллийн тулгалтыг газар дээр нь хийж нэгж талбарын дугаар алдаатай бүртгэгдсэн гэх 1467 бүртгэлийн нотлох баримтад тулгалт хийж эх нотлох | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | баримтыг үндэслэн засварлав. Иргэний бүртгэлийн чиглэлээр нэмэлт өөрчлөлтийн 143 бүртгэл хийсэн. Иргэний улсын бүртгэлийн газарт нэмэлт өөрчлөлтийн бүртгэл 98, нөхөн бүртгэлд 202, хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 2 иргэний холбогдох материалыг хүргүүлэн мэдээллийн сангийн зөрчлийг арилгасан. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх зорилгоор УБЕГазрын Иргэний улсын бүртгэлийн газраас 2023 оны 11 сарын 9-ний өдөр ИУБГазраас 884 иргэний бүртгэлийн жагсаалт ирсэн. Дутуу цахимжсан 480 хувийн хэргийн 1440 маягтыг архивын санд цахимжууллаа. Нийт 2932 | |
| 4 | **Зорилт 4.**<br>Бусад байгууллага, орон нутгаас хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг шийдвэрлүүлж ажиллана. | Бусад эх үүсвэр 10 сая | Дэмжлэг үзүүлсэн мөнгөн дүн | 10,0 | 5,0 | 5,0 | Тогтвортой амьжиргаа төслөөс шууд бусаар үй ажиллагааны зардалд 2,5 сая төгрөгийн дэмжлэг, ГБХЗХГазар 600,0 мян төгрөг, Салхит уурхайн 250 ээлжийн албан хаагчдад төрийн үйлчилгээ үзүүлэхэд шатахуун үйл ажиллагааны зардал 1,6 сая төгрөгийн дэмжлэгийг шууд бусаар үзүүлж хамтран ажиллалаа. Мерит төслөөс Нээлттэй хаалганы өдөрлөгийн үйл ажиллагаанд брошур, тараах материал 300,0 мян төгрөг. Тоног төхөөрөмжийн чанар, ашиглалтын байдлыг аймгийн удирдлагуудад танилцуулж, бүртгэлийн өдөрлөг зохион байгуулснаар орон нутгийн төсвөөс 20,0 сая төгрөгийн дэмжлэг ИТХурлаар батлуулав. КОЙКА төслийн 100 хувийн санхүүжилтээр /15,0 сая төг/ 1 албан хаагч 14 хоногийн гадаад сургалтад хамрагдав.<br>Нийт 40,0 сая төгрөг. | 100/100 |
| 4.1 | Дундговь аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон | - | Хамтран | 2 | 2 | 1 | 2023 онд Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах | | ажилласан тоо | | | | “Тогтвортой амьжиргаа -3” төсөлтэй хамтран хөдөөгийн багийн иргэдэд бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх, цахим үйлчилгээний талаарх мэдээлэл хүргэх зорилгоор хөдөөгийн 13 суманд 2 албан хаагч ажиллаж хамтран ажиллах гэрээний дагуу шатахуун, томилолтын зардал 2,5 сая төгрөгийн дэмжлэгийг авлаа. ГХБХБГазартай хамтран хаягжуулалтын санг цэгцлэх, сумдад кадастрын бүртгэлтэй хамт явж улсын бүртгэл хийж уг үйл ажиллагаанд 2 сумыг хамруулан ажиллалаа.<br>2. Аймгийн ГБХЗХГазартай хамтран ажиллаж 12 хосын гэрлэлтийг ёслол төгөлдөр баталж санхүүжилт 1200,0 төгрөгийн бодит дэмжлэгийг авлаа.<br>3. Салхитын мөнгөний уурхайн удирдлагуудтай хамтран ажиллаж тус уурхайн ээлжийн ажилчдад нээлттэй өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулж уг арга хэмжээний шатахуун үйл ажиллагааны зардал 1,5 сая төгрөгийн дэмжлэгийг шууд бусаар үзүүлж хамтран ажиллалаа. | |
| 4.2 | Аймаг, сумдын ЗДТГазартай хамтран ажиллах | - | Арга хэмжээний тоо | 3 | 3 | 2 | Аймгийн ЗДТГазарт ажлын байрны нөхцөлийг сайжруулах талаар санал төсөл боловсруулан хүргүүлснээр тус хэлтсийн ажлын байранд урсгал засвар хийх 7,7 /долоон сая долоон зуун мянга/-н төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлж ажиллах нөхцлөө сайжруулсан. Говь-Угтаал сумын сүлжээний төхөөрөмжийг шинэчилж 400,0 төгрөгийн дэмжлэг авч хэвийн ажиллагаанд оруулсан. Дэрэн, Өлзийт сумдын ЗДТГазартай хамтран ажиллаж шатахуун хоол унааны зардлыг /500,0 төг/ шийдвэрлүүлэн малчдын өдөрлөгт | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оролцсон 350 иргэнд Тоон гарын үсэг олгож бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчилан үйлчилгээ үзүүллээ. Эрдэнэдалай сум, Дэрэн сумдад төлбөрийн Гэрэгэ системийн хөрөнгийн асуудлыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бүрэн шийдвэрлүүллээ.<br>12 суманд Гэрлэлтийн булан тохижуулж 3,5 сая төгрөгийн санхүүжилтийг сумдын ЗДТГазраас шийдвэрлүүллээ. | |
| 4.3 | Хот хөдөөгийн шинэ сэргэлтийн бодлогын ажлын хэсэгтэй хамтран ажиллах | - | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | 0 | 1 | 1 | 1.“Нээлттэй Дундговь”, Хөрөнгө оруулагчдын чуулганд хамтран ажиллах байгууллагаар сонгогдож арга хэмжээнд оролцож төрийн үйлчилгээний шуурхай байдалд хамтран ажиллах сурталчилгааа, мэдээллийг иргэдэд өгч бүртгэлийн үйлчилгээг зөөврийн төхөөрөмжөөр үзүүлж ажиллалаа.<br>2.Амьдрах орчны эрсдэлийг бууруулах аяны хүрээнд дэд ажлын хэсгийг ахлан хаягжуулалтын асуудлыг аймгийн хэмжээнд цэгцлэхээр холбогдох байгууллага, иргэдэд мэдээлэл өгч үндэсний телевиз, орон нутгийн мэдээллийн хэрэгсэлээр сурталчилгаа явуулж иргэдийн хүсэлтээр, программын түвшинд хаягийг цэгцлэх ажлыг хийж эхэллээ.<br>3. Тус хэлтсээс санаачлан Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа ‘’Шинэ сэргэлтийн бодлого’’-ын ‘’Хөдөөгийн сэргэлт’’-ийн хүрээнд Дундговь аймагт улсын бүртгэлийн үйлчилгээ, банк санхүүгийн байгууллагуудын үйлчилгээг шуурхай авах таатай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Улсын бүртгэлийн хэлтэс, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Нийгмийн даатгалтын хэлтэс,ХХҮГазар, банк санхүүгийн байгууллагууд чөлөөт уулзалтыг зохион байгууллаа. Төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулах, чирэгдэл үүсгэхгүй байх, иргэдийг цахим орчинд төрийн үйлчилгээ авах чадварыг нэмэгдүүлэх, байгууллага хоорондын мэдээлэл солилцоог сайжруулахад анхан шатанд шийдвэрлэж болох зарим асуудлыг хамтын ажиллагаан дээр шийдвэрлэх ,холбогдох дүрэм журамд өөрчлөлт оруулах саналыг дээд шатны байгууллагууддаа хүргүүлэх саналуудыг нэгтгэн салбар бүрээр гаргалаа. | |
| 5 | **Зорилт 5**.<br>Чадахуйн зарчимд суурилсан АТТ-д заасан шалгуурыг хангах хүний нөөцийн эзлэх хувийг дээшлүүлнэ | - | Эрх зүйч мэргэжлээр төгссөн албан хаагчийн тоо | 0 | 2 | 2 | Дэрэн, Хулд сумын Улсын бүртгэгч нар эрх зүйч боловсрол эзэмшиж төгссөн. Өлзийт, Хулд сумын бүртгэгч нар Удирдлагын академийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад сууж байна. Цагаандэлгэр, Говь-Угтаал сумын бүртгэгч нар ЭХЭУБүртгэгчээр дэвшин ажиллаж уг сумдад АТТ-ын шаардлагыг хангасан томилгоог хуульд нийцүүлэн хийв. Хэлтсийн удирдлага БНСУлсын Шүүхийн дэргэдэх төрийн албан хаагчдын сургалтын төвд 14 хоногийн танхимын сургалтад хамрагдаж бүртгэлээр мэргэшүүлэх сертификат авав. Хүний нөөцийн хангалт 100 хувь | 87,1 |
| 5.1 | Арга хэмжээ 1<br>Байгууллагын 2023 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх | БТөсөв 1,0 сая | Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь | 100 | 100 | 100 | 2023 оны сургалтын төлөвлөгөөг 16 заалт бүхий боловсруулан баталж хэрэгжүүлж ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь. Тасарсан сургалт байхгүй. Төлөвлөгөөнөөс гадуур албан хаагчдыг чадавхжуулах чиглэлээр санаачилж хийсэн дотоодын сургалт 8. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Санхүүжилт 1,5 сая төгрөг | |
| 5.2 | Арга хэмжээ 2<br>Байгууллагын ахмадын санг журмын дагуу хөтлөх, зарцуулах | АСан 3,5 сая | Ахмадад дэмжлэг үзүүлсэн тоо | 2 | 1 | 2 | 2023 оны 11 сарын 01–ны байдлаар байгууллагын 6 ахмадад 2023 оны сар шинийн баяраар тус бүр 130.0 мянга, нийт 780.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл, Мөн 2-р сард өндөр настан Г. Цогтсайханд амьдрах орчноо сайжруулахад нь зориулж 3,000.000 сая, 10-р сард өндөр настан Ж.Энхжаргалд өөрийн гаргасан хүсэлтийн дагуу 1,000.000 төгрөгийн нэг удаагийн дэмжлэг нийт 4,780.0 мянган төгрөгийг Ахмадын сангаас зарцуулсан. 2023 оны 1-р улиралд ЭХЭУБ-ийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Ш.Нарангэрэл, 2 улиралд Дэлгэрцогт сумын улсын бүртгэгч О.Улаанхүү нар өндөр насны тэтгэвэрт гарч нийт 57,363.9 мянган төгрөгийн тэтгэмж олгогдсон. 3-р улиралд бичиг хэрэг Д.Наранцэцэгт өндөр насны тэтгэвэрт гарч тэтгэмжийн мөнгөн дүн нь хянагдсан, санхүүжилт нь орж ирээгүй тул олгогдоогүй байна. | 100 |
| 5.3 | Арга хэмжээ 3<br>Хүний нөөц сургалтын нэгдсэн системд байршуулсан цахим сургалтад хамрагдах | - | Хичээл судалж шалгалт өгсөн албан хаагчдын тоо | 16 | 20 | 28 | Сургалтын системд тус хэлтсийн 28 албан хаагч нэвтрэх эрх авч онлайнаар хичээллэн, ерөнхий мэдлэг, ИУБГ, ЭХЭУБ, ХЭУБ, УБНА гэсэн 5 төрлийн шалгалт өгсөн бөгөөд хандалт 28, шалгалтаа бүрэн өгсөн албан хаагч 24 байна. | 70 |
| 5.4 | Арга хэмжээ 4<br>Албан хаагчдыг сайн дурын даатгалд хамруулах | 500,0 хамтын сан | Даатгалд хамруулсан албан хаагчдын тоо | 0 | 15 | 15 | Аймгийн МИГ даатгалын салбартай хамтран ажиллах гэрээ байгуулан сайн дурын даатгалд хамрууллаа. Хамтын сангаас 500,0 төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж 23 албан хаагчтай гэрээ байгуулсан. | 100 |
| 5.5 | Арга хэмжээ 5<br>Албан хэргийг хос бичгээр хөтлөх ажлыг турших | - | Туршилтын тоо | 0 | 10 | 20 | EDOC системд тус хэлтсийн А5 албан бичгийн баланкийг монгол бичгээр стандартад нийцүүлэн оруулсан. Цахим | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | монгол бичгийн программыг нэвтрүүлж аймгийн хэлний бодлогын зөвлөлөөс зохион явуулсан уралдаанд амжилттай оролцож хэлтсийн дарга Ж.Өлзийжаргал 5-р байр эзэлсэн. “Говийн ирээдүй цогцолбор” сургуулийн Монгол хэл уран зохиолын багш М.Нямаа монгол бичгийн 24 цагийн модуль сургалтыг зохион байгуулж ахисан шатанд монгол бичгээр компьютерт бичих чадварт албан хаагчид суралцаж байна. | |
| 5.6 | Арга хэмжээ:6<br>Сумдын бүртгэгч нарын үйл ажиллагаанд зөвлөн туслах хяналт шинжилгээ үнэлгээ хийх | - | Тухайн жилд ХШҮ зохион байгуулсан сумын тоо | 1 | 1 | 3 | хяналт шалгалтын төлөвлөгөөг улирал бүрээр 6 заалтын хүрээнд гаргаж төлөвлөгөөт шалгалт 22, төлөвлөгөөт бус 1 шалгалтыг тус тус хийлээ.<br>2023 онд иргэн, ЭХЭУБ, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны явцад гарах зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2650 бүртгэлд хяналт шалгалт хийгээд байна. ажлын төлөвлөгөө боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хангана. Иргэний улсын бүртгэлийн 35, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 136 бүртгэлд алдаа зөрчил илэрсэн бөгөөд тухай бүр улсын бүртгэгчид өгч засч ажиллалаа. Тайлант хугацаанд 38 дүгнэлт үйлдсэнээс эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 15, иргэний улсын бүртгэлийн 23 байна.<br>Сумдын улсын бүртгэгч нарын ажлыг өдөр бүрийн бүртгэлийн мэдээг авдаг “сумд бүртгэл” группд тавьсан мэдээнээс хамаарч тухай бүр хянаж алдаа зөрчил гаргах тохиолдолд засуулж явсанаар улсын бүртгэгч нарын алдаа багассан. Энэ нь Хяналтын улсын байцаагчийн гаргаж буй дүгнэлтийн тоогоор харагдаж | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байна. Дундговь аймгийн хэмжээнд бүртгэлийн алдааны тоо цөөрч, байцаагчийн дүгнэлт 2022 оны мөн үеийнхтэй харьцуулахад 50%-иар буурсан байна. | |
| 5.7 | Арга хэмжээ 7<br>Хүчингүй болгож байгаа үнэт цаасны зарцуулалтын тооцоо, тайланг бүртгэгч бүрээр сар бүр гаргаж хяналт тавих | - | Бүртгэгчийн буруугаас хүчингүй болсон үнэт цаасны тооны бууралт | 125 | 50 | 50 | 2023 оны жилийн эцсийн байдлаар 105 үнэт цаас хүчингүй болсон байна Адаацаг-3, Баянжаргалан-16 Говь Угтаал-3, Гурвансайхан-1, Дэлгэрцогт-1, Дэлгэрхангай-8, Луус-2, Өлзийт-5, Өндөршил-5, Сайнцагаан-23, Хулд-2, Цагаандэлгэр-7, Эрдэнэдалай-1, Хуулийн этгээдийн улсын бүртгэгч Л.Мөнхсарнай- 2 Н.Угантуяа- 2 О.Ганцэцэг- 5, Гэрэлтуяа- 4 Ш.Чулуун жаргал- 15 тус тус хүчингүй болгосон бөгөөд цаашид анхаарч ажиллахыг зөвлөмж болголоо. Үүнээс техникийн болон программын алдаа 63, бүртгэгчийн буруутай үйлдлээс 42 байна. Хяналт тавьж хариуцлага тооцож ажилласнаар бүртгэгчийн буруутай үйлдлээс үүдэлтэй үнэт цаас хүчингүй болголт 33,6 хувиар буурсан байна. | 70 |
| 6 | **Зорилт 6.** Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангана. | - | Нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг ил тод байршуулсан байх | 46 | 98 | 98 | www.dundgivi.burtgel.gov.mn хаягийг www.burtgel.gov.mn линкээр холбож мэдээллийг шуурхай авах боломжийг бүрдүүлсэн.<br>98 шалгуур үзүүлэлтийн дагуу сайтад мэдээлэл бүрэн оруулж хяналт хийсэн. QR код үүсгэн мэдээлэл авах боломж бүрдүүлсэн. УБЕГ болон АЗДТГ-ын үнэлгээгээр 100%-тай үнэлсэн. Тухай бүр баяжуулалтыг хийж хэвшсэн. | 100 |
| 6.1 | Арга хэмжээ 1<br>Аймаг орон нутгийн мэдээлэл болон байгууллагын үйл ажиллагааг мэдээллийн самбар, | - | Цахим, мэдээллийн самбарт байршуулсан | 80 | 50 | 150 | 2023 онд УБЕГазар, бүртгэлийн хууль тогтоомж, үйл ажиллагаатай холбоотой 85 мэдээ мэдээлэл бэлтгэн хэлтсийн веб сайт, фэйж хуудсанд байршуулсан | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэвлэл мэдээлэл, олон нийтийн цахим сүлжээгээр сурталчлах | | мэдээллийн тоо | | | | байна. УБЕГ, АТГ, ДУ ЗДТГ, бусад холбогдох байгууллага болон хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой нийт 248 мэдээллийг фейсбүүк хуудсанд пост хийн түгээсэн ба үүнээс ЗДТГ-ын 58 мэдээллийг Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нээлттэй групп,Бүртгэлийн хэлтсийн фэйж хуудсанд шээр хийн түгээсэн байна. | |
| 6.2 | Арга хэмжээ 2 Байгууллагын цахим хуудас, фэйсбүүк хуудсыг идэвхижүүлж, хандалтын тоог нэмэгдүүлэн, дагагчийн тоог өсгөх | - | Цахим хуудасны хандалтын тоо | 1000 | 500 | 500 | 85 мэдээллийг нийт 3827 хандалт авсан байна. | 100 |
| | | - | Фэйсбүүк групп дагагчийн тоо | 2000 | 1000 | 2100 | Фейсбүүк групп 2,2 мянган дагагчтай болсон байна. Фейсбүүк фэйж хуудас 1,6 мянган дагагчтай болж нэмэгдсэн байна. | |
| 6.3 | ХАрга хэмжээ 3 ШҮнэлгээний зөвлөмжийг төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллах | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100 | 80 | 100 | Зөвлөмжийг хэрэгжүүлэх 19 арга хэмжээг төлөвлөн эхний хагас жилд 94,6 хувьтай хэрэгжүүлэн жилийн эцэсийн байдлаар 100 хувьд хүргэж хэрэгжүүлэн ажиллалаа. Төлөвлөгөөний хэрэгжилтийг гарган ХШҮнэлгээнд хугацаанд нь хүргүүлсэн. | 100 |
| 7 | **Зорилт 7.** Байгууллагын соёлыг нэвтрүүлж, ёс зүйтэй албан хаагчдыг бүрдүүлж, харилцаа, хандлагыг сайжруулна. | Хамтын сан 1 сая | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3 | 1 | 2 | Хэлтсийн бүх албан хаагчдад цахим хэлбэрээр “байгууллагын стандарт, ёс зүйн” сэдэвт 8 төрлийн хичээл, сургалт, уулзалтын хуваарь гарган баталлаа. “Манлайлал” “Хувь хүний хөгжлийн амжилтад хүрэх алхам” “Байгууллагын соёл” сэдвүүдээр тус тус илтгэл мэдээлэл хүргэж ажиллалаа. Хэлтсийн гэр бүлийн зөвлөлөөс албан хаагч нарын ажлын байранд эерэг харилцаа, хандлага нэмэгдүүлэх соёлыг төлөвшүүлэх, багаар ажиллах чадварыг идэвхжүүлэх зорилгын хүрээнд “Идэвхжүүлэх” 5-н өдрийн хөтөлбөр гаргаж даваагаас баасан хүртэл ажлын 5 өдрийг “Азын өдөр”, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | "Талархах өдөр", "Хайрлах өдөр", "өгөх өдөр","Мэдэх өдөр"болгон үйл ажиллагаа зохион байгууллаа. | |
| 7.1 | Арга хэмжээ:1<br>Албан хаагчдад харилцаа, хандлага, хувь хүний хөгжил, ёс зүй сэдэвт сургалтыг зохион байгуулах, төлөвшүүлэх | 0,2 сая БТөсөв | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | 27 | 29 | 29 | Шинээр томилогдсон 4 албан хаагчдад хууль, журам, программын сургалтыг ажлын байранд зохион байгуулж мэдлэг мэдээлэл олголоо. Улсын бүртгэлийн ажилтны өдрөөр нийт албан хаагчдад багаар ажиллах, ёс зүйтэй албан хаагч өглөөлөгийн арга хэмжээг шинэлэг хэлбэрээр зохион байгууллаа. Бүх албан хаагч 100 хувь хамрагдсан.<br>Төрийн албаны ёс зүйн тухай хуулиар танхимын болон цахим сургалт зохион байгуулж мэдлэг сорих тестээр шалгалт авлаа. Жишиг тестийг УБЕГазрын хэмжээнд ашиглахаар сургалтын хэлтэс гарын авлага болгон авлаа. | 100 |
| 7.2 | Арга хэмжээ:2<br>Албан хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, нийтийн биеийн тамирын арга хэмжээнд оролцуулах | - | Спортоор хичээллэдэг албан хаагчдын эзлэх хувь | 15 | 40 | 40 | Энэ жилдээ эрүүл жиндээ аяны хүрээнд тус хэлтсийн 12 албан хаагч нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэж БЖИлүүдэлгүй болсон. Теннисээр 1, шагайн харваа 2, автоспорт 1, спининг 3, бүжиг 1 албан хаагч тогтмол хичээллэж үр дүн гаргасан. Волейволын уралдаан тэмцээнд 8 тамирчин тогтмол оролцож хичээллэж байна. УБЕГазрын хэмжээнд зохион байгуулагдсан спортын арга хэмжээнд оролцож эрэгтэй сагс мөнгө, эмэгтэй волейвол мөнгө, эмэгтэй теннис төрлөөр алтан медаль хүртэж нийт дүнгээр шижин явах цомын эзэн болов. | 100 |
| 7.3 | Арга хэмжээ:3<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлүүлэх ээлтэй орчин бий болгох | БТөсөв 200,0 мян | Арга хэмжээний тоо | - | 2 | 2 | Хараань бэрхшээлтэй 65 ба түүнээс дээш насны ахмад настан, жирэмсэн, нярай хүүхэдтэй харилцагч, түүнчлэн нас барсны бүртгэл хийлгэх харилцагчдад дараалал харгалзахгүйгээр үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд тухайн өдөр үйлчилж | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгаа ажилтны нэр, албан тушаалыг харилцагчдад харагдахуйц байдлаар шинэчилж байршуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх үйлчилгээг хүртээмжтэй болгох албан хаагчдыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хэрхэн харьцах харилцааны арга зүй дохионы хэлний анхан шатны мэдлэг олгох талаар УБЕГазраас зохион байгуулсан дохионы хэлний сургалтад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч, хяналтын улсын байцаагч нар хамрагдсан.<br>-Тус аймагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд тус төвийн дохионы хэлний сургалтад хэлтсийн албан хаагчид хамрагдлаа. Иргэний улсын бүртгэлийн төрөлт, гэрлэлт, эцэг тогтоолтын бүртгэлийн өргөдлийг харааны бэрхшээлтэй иргэдэд зориулан барелл үсгээр хэвлүүлж өгөхөөр өргөдлийн загварыг гаргуулан авсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ авах нөхцөл боломжоор хангах, техник хэрэгсэлийг сайжруулах зорилгоор сонсголын бэрхшээлтэй харилцагчид зориулсан чанга, тод дуутай микрофон , харааны бэрхшээлтэй харилцагчид зориулж мэдээллийн самбар дахь мэдээллийг Arial mon 16 үсгийн фонтоор хэвлэн байршуулсан. | |
| 7.4 | Арга хэмжээ: 4<br>Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийн бэлтгэл ажлыг хангах гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах | Байгууллагын төсөв 0,5 сая | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 50 | 100 | Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгт бэлтгэж Иргэний бүртгэл, мэдээллийн штабын 5 гишүүнд аранз бэлтгэн хувцаслалтыг жигдрүүллээ. Бэлэн байдлыг хангах төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | **Зорилт 8** Аймгийн тохижилтын үйл ажиллагаанд оролцож ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ. Мод тарьж, арчилж ургуулна. | 200 мян төг хамтын сан | Тариалсан модны тоо | 30 | 30 | 30 | Тэр бум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэлтсийн хамт олон тарьсан модны хашаа орчим, модны ухсан нүхний хогийг цэвэрлэж, 5 удаа усалж намрын цэнэг усалгаагаар нийт 60 тарьцны арчилгааг хийлээ. Нөхөн тариалалт 30ш хайлаас суулган ургуулж байна. Ургалтын хувь 90. Усалгаа арчилгааны зардалд 250,0 төгрөг зарцуулаад байна. | 100 |
| 8.1 | Арга хэмжээ:1 Жилд тарих модны тоог нэмэгдүүлэх, арчилж тордох, хамгаалах | - | Тухайн жилд тарьсан модны тоо | 30 | 15 | - | Хэлтсийн албан хаагчид хувийн хэрэгцээнд 20ш алимны мод худалдан авч суулган 90 хувийн ургалттай байна. Төгсөлт, ТББ-тай хамтран 9 албан хаагч 120 мод тариалсан. | 100 |
| 8.2 | Арга хэмжээ:2 Байгууллага дээр /баттерей/ хог хаягдлаа ангилан ялгах хогийн сав байршуулах | - | Байршуулсан хог ангилан ялгах савны тоо | 0 | 1 | 1 | Нэг цэгийн үйлчилгээний танхимд батерей болон хог ангилан ялгах савыг гарын доорх материалаар хийж байршуулсан. Хэвийн ажиллагаатай. Албан хэрэгцээнд ашиглагдаж ашиглалтаас гарч байгаа батерейг ангилан ялгах савыг үйлчилгээний танхимд байршуулж хор хохирлын талаар нийтэд сурталчилж видео реал хийж ажиллалаа. | 100 |
| 8.3 | Арга хэмжээ:3 Албан хаагчдад хог ангилан ялгах | - | Сургалтад хамрагдсан | - | 18 | 18 | Ид шидийн орон хүүхэд хөгжлийн төвд хэрэгжсэн UPDATE хөтөлбөрийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ач холбогдлын талаар сургалт зохион байгуулах | | албан хаагчдын тоо | | | | оролцогч хүүхдүүдээр "ХОГТОЙ НАЙЗЛАЯ" нөлөөллийн арга хэмжээнд хамтран оролцож ангилан ялгахын ач тус, хор хөнөөл, байгальд орших хугацааны талаарх мэдээллийг авлаа. Сургалтад албан хаагчид бүрэн хамрагдлаа. | |
| Зорилтын дундаж хувь | | | | | | | | 97,7 |
| Арга хэмжээний дундаж хувь | | | | | | | | 96,5 |
| Хэрэгжилтийн дундаж хувь | | | | | | | | 97,1 |

Төлөвлөгөөг үнэлсэн : *Төсвийн шууд захирагч*

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА ........................ Ц.МӨНХБАТ

...............................

*/огноо/*

*Тайлагнасан :* *Нэгжийн дарга*

ДУНДГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА ........................ Ж.ӨЛЗИЙЖАРГАЛ

3429792
ГСТ7460 0823010006

...............................

*/огноо/*

ХШҮнэлгээ хийсэн :

ХЭЗ ХЭЛТСИЙН ДАРГА ........................ Л.БАЯРСАЙХАН

...............................

*/огноо/*